



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/419

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дах заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны Хуралдааны III/05 дугаар тогтоол, 2023 оны XVII дугаар Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 17/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх хүүхэд, залуучуудын хөгжлийн ордонд байрлах аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн өрөөг тохижуулах ажилд шаардагдах 850,000 (найман зуун тавин мянга) төгрөг гаргахыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх хөрөнгийг хүүхэд хамгаалалыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

